



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 07

Урт

┌ Сонгуулийн хэсэг байгуулж нутаг дэвсгэр, ┐
төвийг батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчдын санал авах, тоолох хэсгүүдийг Гоёот, Баясах, Тост, Урт, Овоот нэртэй байгуулж нутаг дэвсгэр төвийг хавсралтаар баталсугай.

2. Хэсгийн нутаг дэвсгэр, төвийг иргэдэд мэдээлж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

3. Уг тогтоолыг холбогдох газарт уламжлахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Одончимэг/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

Гурвантэс сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 07 тоот тогтоолын хавсралт



Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн

хэсгийн нутаг дэвсгэр, төв

№	Хэсгийн нэр	Хэсэгт хамрагдах нутаг дэвсгэр	Хэсгийн төв /санал авах байр/
1	Гоёот	Гоёот багийн нутаг дэвсгэр	4-р багийн төв
2	Баясах	Баясах багийн нутаг дэвсгэр	Хуучин соёлын төв
3	Тост	Тост багийн нутаг дэвсгэр	Шинэ Соёлын төв
4	Урт	Урт багийн нутаг дэвсгэр	Спорт цогцолбор
5	Овоот	Хилийн цэргийн 0166-р анги, Шивээ хүрэн гааль, Нарийн сухайт уурхай, хилийн цэргийн анги орчмын Урт багийн айл өрх, иргэд	Хилийн цэргийн ангийн Соёлын төв



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 08

Урт

Төрийн дээд шагналд
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22-р зүйлийн 22.1.15 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын Тост багийн өндөр настан Гунгаагийн Доржийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулах саналыг дэмжсүгэй.

2. Шагнуулахаар тодорхойлсон материалыг холбогдох дээд байгууллагад уламжлахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 09

Урт

Г Хүүхдийн төлөө зөвлөл байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүүхдийн төлөө зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Зөвлөлийн дарга - Сумын Засаг дарга

Зөвлөлийн гишүүд: Эрүүл мэндийн төвийн хөтөлбөр хариуцсан ажилтан

Сумын цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч

ЕБС-ийн нийгмийн ажилтан

3-р Цэцэрлэгийн арга зүйч

ЕБС-ийн Хүүхдийн элч

ЕБС-ийн эцэг эхийн зөвлөлийн дарга

28-р цэцэрлэгийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын Дотоод ажил, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын тайланг жил бүрийн 11-р сарын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хуралд танилцуулахыг хүүхдийн төлөө зөвлөлийн дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороо /Г.Гангамаа/-нд даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.ОТГОНБАЯР